



2026 ОНЫ 3-Р САРЫН 11

ТННЭ-ИЙН МАЛЫН ГАРАЛТАЙ ШИРХЭГТИЙН СТАНДАРТ

ХУВИЛБАР 1.02



ТОГВОРТОЙ НООС НОЛУУРЫН ЭВСЭЛ

МЭДЭГДЭЛ

Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэл (ТННЭ)-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт болон бусад баримт бичгүүд, тэдгээрт эш татсан мэдээллийн эх сурвалжийн үнэн зөв эсвэл бүрэн бүтэн байдалд ямар нэг амлалт, баталгаа гаргаагүй болно. Энэхүү стандартын хэрэгжилт нь олон улсын, үндэсний, бүсийн болон орон нутгийн засаг захиргааны шийдвэр, хууль тогтоомж, дүрэм журам, захирамж эсвэл бусад албан ёсны баримт бичгүүдийн шаардлагыг орлох, зөрчих, өөрчлөх зорилгогүй. ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандартыг дагаж мөрдөх нь сайн дурын үндсэн дээр байх бөгөөд энэ нь ТННЭ болон/эсвэл түүний гишүүд эсвэл оролцогч талуудын хуулийн дагуу хүлээх хариуцлага, эдлэх эрхийг бий болгох, тодорхойлоход чиглэгдээгүй. Хэрэглэгч нь стандартын шаардлагад нийцээгүйн төлөө ТННЭ болон/эсвэл түүний гишүүд эсвэл оролцогч талуудын эсрэг арга хэмжээ авах хууль эрх зүйн шалтгаан байхгүй.

ТННЭ-ийн тухай

ТННЭ нь малчид, үйлдвэрлэгчдээс эхлээд жижиглэн худалдаа эрхлэгчид хүртэлх малын гаралтай ширхэгтийн нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх чиглэлд ажилладаг ашгийн бус олон улсын байгууллага юм. Бидний алсын хараа бол хүн, мал/амьтан, байгаль орчны эрүүл, сайн сайхан байдлыг сахин хамгаалдаг хариуцлагатай, оролцоот олон улсын байгалийн ширхэгтийн үйлдвэрлэлийг бий болгох юм. ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт (цаашид Стандарт гэх) нь дараах таван үндсэн зарчмаас бүрдэнэ: үр ашигтай удирдлага зохион байгуулалт; зохистой хөдөлмөр эрхлэлт; биологийн олон янз байдал ба газар ашиглалт; малын тавлаг байдал; ширхэгтийн чанарын сайжруулалт юм.

Стандартын тухай

ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт нь малын гаралтай ширхэгтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд баримтлах ТННЭ-ээс тодорхойлсон шилдэг туршлагууд юм. Энэ нь норматив баримт бичиг бөгөөд ТННЭ-ийн [Стандарт боловсруулах журам](#)-д тодорхойлсны дагуу өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлага, шинээр гарч ирж буй сайн туршлагуудад үндэслэн стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах эрх нь ТННЭ-д хадгалагдана. ТННЭ-ийн албан ёсны хэл нь Англи хэл бөгөөд орчуулагдсан баримт бичгүүдээс тодруулах зүйл гарвал Англи эх хувийг лавлагаа дагана. Мөн таны ашиглаж буй хувилбар нь стандартын хамгийн сүүлийн хувилбар мөн эсэхийг нягтална уу. ТННЭ-ийн цахим хуудас дээр зөвхөн хамгийн сүүлийн, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартын хувилбар нь байнга байрших болно.

Энэхүү стандартын чанарын зорилгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [Стандартын ажлын удирдамж](#)-аас авах боломжтой.

Энэхүү Стандартад хамаарах малын гаралтай ширхэгт

Уг стандарт нь дараах малын гаралтай ширхэгт/малд хамаарна:

- Ямааны ноолуур [**Орчуулагчийн тайлбар:** одоогоор уг стандарт нь зөвхөн ямааны ноолуурыг хамаарч байгаа тул энэхүү стандартад дурдсан “мал” гэдгийг ямааг, “ширхэгт” гэдгийг ноолуур гэж ойлгоно.]

Эш татсан болон норматив баримт бичиг

ТННЭ-ийн бусад баримт бичгүүд

- [ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандарт](#)
- [ТННЭ-ийн Цэвэр ноолуур боловсруулах стандарт](#)
- [Брэндийн таниулах удирдамж](#)
- [ТННЭ-ийн Үнэлгээ, баталгаажуулалтын журам](#)
- [ТННЭ-ийн Нэр томъёоны тайлбар толь](#)
- [ТННЭ-ийн Стандарт боловсруулах журам](#)

ТННЭ-ийн цахим холбоос

- [ТННЭ – Тохирлын үнэлгээний байгууллагууд](#)

- [ТННЭ-ийн Мөшгөлтийн цахим систем](#)

Улс орны удирдамж

Энэхүү стандартад малын гаралтай ширхэгт үйлдвэрлэгч зарим орны онцлогт тохируулан боловсруулсан удирдамжийн баримт бичгүүд дагалдана. Энэхүү удирдамж нь өөрөө норматив баримт бичиг биш боловч норматив шаардлагыг давтаж, бататгаж эсвэл тодруулж өгнө.

Улс орны удирдамжийг ТННЭ-ийн цахим хуудас дээрх [Мэдээллийн сан](#) цэсээс харах боломжтой.

Бидэнтэй хэрхэн нэгдэх вэ?

“ТННЭ-ээр баталгаажсан” (цаашид SFA Certified гэж нэрлэнэ) малын гаралтай ширхэгтийн үйлдвэрлэл, худалдаанд оролцож эхлэхийн тулд та энэхүү стандартын дагуу гуравдагч этгээд буюу тохирлын үнэлгээний байгууллагаар баталгаажуулалт хийлгэсэн байх шаардлагатай бөгөөд баталгаажсан ширхэгтийн үйлдвэрлэл, худалдаанд оролцох эрх нь баталгаажуулалтын үнэлгээний дүгнэлт болон олгосон гэрчилгээний хүчинтэй байдал-аас хамаарна.

Баталгаажуулалтын үр ашиг болон энэхүү үйл явцад хэрхэн хамрагдах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидний бэлтгэсэн ["Баталгаажуулалт хийлгэх"](#) зааварчилгаатай танилцана уу.



Энэхүү стандартын шинэчлэл

ТННЭ нь энэхүү стандартыг эзэмшиж, хариуцдаг. Энэхүү стандарт эсвэл ТННЭ-ийн илүү өргөн хүрээний хөтөлбөрийн бусад стандартын загвар болон/эсвэл хэрэгжилтийн талаарх аливаа асуудал, санал хүсэлтийг [ТННЭ-ийн нээлттэй хэлэлцүүлгийн порталаар](#) дамжуулан илгээнэ үү. Стандартын энэхүү үндсэн хувилбарыг нийтэлснээс хойш таван жилдээ багтаан албан ёсны хяналт шинэчлэл хийхээр төлөвлөсөн бөгөөд ирүүлсэн бүх санал, зөвлөмжийг хянан хэлэлцэх явцад нухацтайгаар авч үзнэ.

Хүчин төгөлдөр болох хугацаа

2025 оны 7-р сарын 1-ний өдрийн байдлаар ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт хувилбар 1.0 эсвэл түүнээс өмнөх аль нэг хувилбараар баталгаажуулалт хийлгээгүй боловч 'SFA Certified' бүтээгдэхүүн худалдаалах хүсэлтэй бүх аж ахуйн нэгжүүд 2025 оны 7-р сарын 1-ээс эхлэн ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандартын энэхүү хувилбарын дагуу баталгаажуулалт хийлгэнэ.

2025 оны 7-р сарын 1-ний өдрийн байдлаар ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт хувилбар 1.0 эсвэл түүнээс өмнөх аль нэг хувилбараар баталгаажсан бүх аж ахуйн нэгжүүд 'SFA Certified' бүтээгдэхүүний худалдаанд үргэлжлүүлэн оролцох хүсэлтэй бөгөөд 2025 оны 7-р сарын 1-ний өдрийн байдлаар хүчинтэй Тохирлын гэрчилгээтэй бол гэрчилгээний хугацаа дуусахаас өмнө ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандартын энэхүү хувилбарын дагуу баталгаажуулалт хийлгэнэ.

Энэхүү баримт бичгийг нийтэлсэн өдрөөс эхлэн аж ахуйн нэгжүүд энэхүү стандартын дагуу баталгаажуулалтад хамрагдаж болно.

Энэхүү баримт бичигт шаардлага, зөвлөмж, зөвшөөрөл, боломж болон чадавхыг илэрхийлэхэд дараах үг хэллэгийг ашиглана:

- “...на, ...нэ, ...но, ...нө” төгсгөлтэй бол шаардлага;
- “зохино” гэж төгссөн бол зөвлөмж;
- **“боломжтой”** гэж төгссөн бол зөвшөөрч байгаа;
- “болно” гэсэн төгсгөлтэй бол боломж болон чадавх гэсэн утгыг тус тус заана.
- “үндэслэл бүхий тайлбар” эсвэл “үндэслэл бүхий тайлбартай” гэдэг нь тохирлын үнэлгээний байгууллагад үндэслэл бүхий тайлбар гаргаж өгөх утгатай бөгөөд тэр үйл ажиллагаа нь тухайн норм/стандартын шаардлагаас чөлөөлөгдөхүйц байх юм.

 *Зааварчилгааг илэрхийлнэ. Зааварчилгаа гэдэг нь өөрөө норматив буюу стандартын шаардлага заахгүй ч норматив шаардлагуудыг давтах, бататгах эсвэл тодруулах зориулалттай.*

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Хувилбар	Агуулга	Оруулсан өөрчлөлт	Огноо
1.0	Ноолуурын стандарт v1.1 болон өмнөх хувилбаруудыг орлоно.	ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт v1.0-ын Нэмэлт, өөрчлөлтийн хураангуй -г харна уу.	01/12/2024
1.01	Малын тавлаг байдлын шаардлагуудын тодруулга	ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандарт v1.01-ын Нэмэлт, өөрчлөлтийн хураангуй -г харна уу.	01/06/2025

Үндэслэл	
2026 оны Хоёрдугаар сард санал болгосон тодруулга	
Бага хэмжээний өөрчлөлт	
Хуудасны дугаар	Өөрчлөлт
8	<p>Малын гаралтай ширхэгтийн стандарт v1.01-ын Шаардлага 1.3-д өмнө нь “Энэхүү стандартын дагуу гэрчилгээ авах гэж байгаа эсвэл одоо байгаа гэрчилгээгээ үргэлжлүүлэн эзэмших хүсэлтэй бүх малчдын байгууллагууд ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын өмнөх хувилбараар хийлгэсэн баталгаажуулалтын хүчинтэй хугацаа дуусаагүй байх эсвэл одоо мөрдөж байгаа хувилбарыг хэрэгжүүлж гэрчилгээ авсан байна” гэж тодорхойлсон.</p> <p>Малын гаралтай ширхэгтийн стандартын Шаардлага 1.3-ын зорилго нь Малын гаралтай ширхэгтийн стандартыг хангахаас өмнө Мөшгөлтийн тогтолцооны стандартыг хангасан байна гэх санааг илэрхийлэх зорилго агуулаагүй болно. Тиймээс үүнийг дараах байдлаар өөрчлөв:</p> <p>‘SFA certified’ баталгаажилттай ноолуурыг борлуулж буй бүх бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллагууд нь зарж буй барааг ‘SFA certified’ гэж борлуулахын тулд ТННЭ-ийн Малын гаралтай ширхэгтийн стандарт болон Мөшгөлтийн тогтолцооны стандартын хамгийн сүүлийн хувилбараар баталгаажсан байна.”</p>

Хамрах хүрээ ба баталгаажуулалт

1. Хамрах хүрээний шаардлага

“ТННЭ-ээр баталгаажсан” (цаашид ‘SFA Certified’ гэх) малын гаралтай ширхэгтийг үйлдвэрлэж буй бүх малчдын байгууллага нь тухайн малын гаралтай ‘SFA Certified’ ширхэгтийн/бүтээгдэхүүний худалдаа, шошгожуулалт эсвэл боловсруулалттай холбоотой мэдэгдэл гаргахаас өмнө ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандартын өмнөх хувилбараар хийлгэсэн баталгаажуулалтын хүчинтэй хугацаа дуусаагүй байх эсвэл энэхүү хамгийн сүүлийн хувилбараар зөвшөөрөл бүхий итгэмжлэгдсэн гуравдагч этгээд (Тохирлын үнэлгээний байгууллага, ТҮБ)-ээр баталгаажуулсан **байна**.

■ Энэ баримт бичигт гарах малчдын байгууллага болон бусад нэр томъёоны тайлбар тодорхойлолтыг ТННЭ-ийн Нэр томъёоны тайлбар толиос харна уу.

■ Нэг төрлийн малаас гаралтай байгалийн ширхэгт (болон тухайн ширхэгтийг бий болгож буй малын төрөл)-д нэг гэрчилгээ олгоно. Малчдын байгууллага нь нэгээс дээш төрлийн ‘SFA Certified’ малын гаралтай ширхэгтээр баталгаажуулалт хийлгэх хүсэлтэй бол малчдын байгууллага нь тухайн малын гаралтай ширхэгтийн стандартын баталгаажуулалтын гэрчилгээг тус тусад нь авна. Дэлгэрэнгүй мэдээллийг ТННЭ-ийн Үнэлгээ, баталгаажуулалтын гарын авлагаас үзнэ үү.

1.1 Энэхүү стандартын аливаа нэг шаардлага тухайн малчдын байгууллагын үйл ажиллагаа явуулж буй улсын хуультай зөрчилдөх тохиолдолд тухайн улсын хуулийг **дагана**.

■ Малчдын байгууллага нь дээрх харьяаллаас гадуур үйл ажиллагаа явуулж буй нь энэ заалтаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

1.2 ‘SFA certified’ баталгаажилттай ноолуурыг борлуулж буй бүх бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллагууд нь зарж буй барааг ‘SFA certified’ гэж борлуулахын тулд ТННЭ-ийн Малын гаралтай ширхэгтийн стандарт болон Мөшгөлтийн тогтолцооны стандартын хамгийн сүүлийн хувилбараар баталгаажсан **байна**.

■ Зөвхөн ТННЭ-ийн холбогдох бүх стандартуудын шаардлагуудыг хангасан аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүнийг л ‘SFA Certified’ гэж үзнэ.

2. Баталгаажуулалтын шаардлага

2.1 Малчдын байгууллага нь энэхүү стандартын бүх шаардлагуудыг хангасан **байна**.

■ Шаардлагуудыг “...на, ...нэ, ...но, ...нө” гэж тодорхойлсон. Эдгээр бүх шаардлагуудыг хангасан малчдын байгууллагыг ‘SFA Certified’ гэж үзнэ.

2.2 Малчдын байгууллага нь энэхүү стандартын шаардлагуудаас гадна энэхүү стандартад тодорхойлсон сайжруулах үзүүлэлтүүдийг хэрэгжүүлэх **боломжтой**.

■ Сайжруулах үзүүлэлтүүдийг “**боломжтой**” гэж тодорхойлсон. Энэхүү стандартын шаардлагуудаас гадна эдгээр сайжруулах үзүүлэлтүүдийг бүгдийг нь хангасан малчны байгууллагыг ‘SFA Certified’ гэж үзэхээс гадна, малын гаралтай ширхэгт үйлдвэрлэлд “ТННЭ-ийн шилдэг туршлага”-ыг хэрэгжүүлэгч гэх нэр хүндтэй мэдэгдэл гаргах боломжтой.

Зарчим 1: Үр ашигтай удирдлага, зохион байгуулалт

3. Байгууллагын бүтэц

3.1 Малчдын байгууллага нь удирдах албатай **байна**.

Байгууллага нь тохирлын гэрчилгээг хариуцах бөгөөд тохирлын гэрчилгээнд хамаарах бүх үйл ажиллагааг энэхүү стандартын шаардлагад нийцүүлнэ. Байгууллага нь дараах хэлбэртэй байж болно, тухайлбал: бэлтгэн нийлүүлэгч малчдын байгууллага буюу хоршоо эсвэл нөхөрлөл, малын гаралтай ширхэгтийг худалдан авагчид, түүхий эд бэлтгэлээс эцсийн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бүрэн хэмжээний компани эсвэл дангаараа үйл ажиллагаа явуулдаг бие даасан үйлдвэрлэгч байж болно.

Удирдах алба нь заавал биет оффистой байх шаардлагагүй.

3.2 Малчдын байгууллага нь 'SFA Certified' малын гаралтай ширхэгт бэлтгэдэг нэг эсвэл түүнээс дээш тооны нэгж буюу малчин өрхтэй **байна**.

Нэгж гэдэг нь ихэвчлэн бие даасан ферм эсвэл малчин өрх юм.

3.3 Малчдын байгууллага нь удирдах алба нь байрлах тухайн улсад харьяалалтай хуулийн этгээд эсвэл хувь хүн **байна**.

3.4 Малчдын байгууллага нь тохирлын гэрчилгээний хамрах хүрээнд багтах малчин өрхүүдтэй энэхүү стандартын шаардлагыг хангахад тэдний гүйцэтгэх үүргийг тусгасан гэрээ **байгуулна**.

Энэхүү гэрээ нь бичгээр эсвэл аман байж болох ч хоёр тал гэрээний нөхцөлийг харилцан тохиролцсон байна.

Малчдын байгууллагын аль нэг малчин өрхөд үл тохирол илэрсэн бол тухайн малчдын байгууллагын бүх малчин өрхүүдэд үл тохирол илэрсэн гэж үзэх бөгөөд энэ нь малчдын байгууллага, үл тохирол илэрсэн малчин өрх болон бусад малчин өрхүүдийн гурван талт хамтын үүрэг, хариуцлага гэсэн үг болно.

3.5 Малчдын байгууллага нь ТННЭ-ийн Малын Гаралтай Ширхэгтийн Стандартын шаардлагуудыг хангуулах ерөнхий үүрэг хүлээсэн, удирдлагын төлөөллийг томилсон **байна**.

Энэхүү төлөөлөл нь ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын шаардлагуудыг хангуулах үүргийг мөн хариуцаж байгаа хүн байж болно.

3.6 Малчдын байгууллага нь тухайн удирдлагын төлөөллийн мэдээлэлд орсон аливаа өөрчлөлтийг ТҮБ болон ТННЭ-д ажлын 20 хоногт багтаан **мэдэгдэнэ**.

ТННЭ-д мэдээлэл илгээхэд дараах холбоо барих хаягийг ашиглана: standards@sustainablefibre.org.

4. Сургалт

4.1 Малчдын байгууллага нь бүх өрхүүддээ дараах чиглэлээр жил бүр сургалт санал **болгоно**:

- a) Энэхүү стандартын шаардлагууд, эдгээрийг малчдын байгууллага болон малчин өрхийн түвшинд хэрхэн хэрэгжүүлэх талаарх сургалт;
- b) ТННЭ-ийн Улс орны удирдамжийн сургалт;

- c) ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын шаардлагуудын талаарх сургалт.
- *Малчдын байгууллага нь энэхүү сургалтыг өөрсдөө боловсруулж явуулах шаардлагагүй бөгөөд малчин өрхүүддээ сургалтад хамрагдах боломж олгох үүрэг хүлээнэ. Энэ нь малчдад сургалт авах боломжийг бий болгож, мэдээлэл хүргэх явдал юм.*
 - *ТННЭ болон хамтрагч, түнш байгууллагуудын зүгээс тогтмол сургалт санал болгодог.*
- 4.1.1 Сургалт явуулах хэл болон хэлбэрийн хувьд бүх малчдад хүртээмжтэй **байна**.
- 4.1.2 Малчдын байгууллага нь энэхүү сургалтад бүх малчин өрхүүдээс нэг ба түүнээс дээш хүнийг хамруулах **боломжтой**.

5. Аюултай бодис

- 5.1 Малчин өрх нь дараах зүйлсийг зөвхөн үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэж, **устгана**:
- a) машин тоног төхөөрөмж;
 - b) эм, тариа;
 - *Үүнд вакцин хамаарна.*
 - c) пестицид буюу хортон устгалын бодис;
 - d) бордоо;
 - e) бусад бүх төрлийн аюултай бодисууд.
- 5.2 Малчдын байгууллага нь хортон устгалын бодис, бордоо болон бусад аюултай бодисуудыг хэрэглэсэн малчин өрхөд тухайн бодисыг хэрэглэх заавар, аюулгүй хэрэглээний мэдээллийг агуулсан дагалдах хуудас байгаа эсэхэд хяналт тавина.
- 5.2.1 Малчин өрх нь эдгээр бодисуудыг хэрэглэсэн буюу харьцаж ажилладаг бүх хүмүүс (ажилчид)-т тухайн бодисыг хэрэглэснээс үүдэх эрсдэлийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу ойлгомжтой, тогтмол **таниулна**.

6. Малчдын байгууллагын бүртгэл хөтлөлт, үнэлгээ

- 6.1 Малчдын байгууллага нь дараах бүртгэлийг бүрэн бүтэн, шинэчлэгдсэн байдлаар байгууллагын болон малчин өрхүүдийн түвшинд цуглуулж, тогтмол **хөтөлнө**:
- a) Малчин өрхийн хэрэглэсэн хортон устгалын бодис, бордоо болон бүх төрлийн аюултай бодисын бүртгэлийг өрхийн түвшинд хийж, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
 - b) Аль малчин өрх ажилтан буюу туслах малчин ажиллуулдаг талаарх бүртгэл, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
 - *Тодруулбал, үүнд тухайн малчин өрхийн гишүүн биш гэрээт ажилтан орно.*
 - c) Сургалтын тоо, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
 - d) Малчин өрхийн түвшинд сургалтад хамрагдсан хүний тоо, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
 - e) Энэхүү стандартын шаардлага болон сайжруулах үзүүлэлтүүдийг хэрэгжүүлэхийн тулд малчдын байгууллагын хийсэн үйл ажиллагааны бүртгэл, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;

- f) Өмнөх жил малчин өрхүүдийн ашигласан газар нутаг, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
- g) Газрын харилцаа, байгалийн нөөцтэй холбоотой бүх зөрчил, маргаан, гомдол, тэдгээрийн үр дүн, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
- h) Малчдын байгууллагын хийсэн малын гаралтай ширхэгтийн борлуулалт, үүнд үнэ болон бусад нөхцөлүүд, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
- i) Малчдын байгууллага малчдаас малын гаралтай ширхэгт худалдан авсан/төлбөр хийсэн бүртгэл, үүнд үнэ болон бусад нөхцөлийн хамт, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
- j) Малчдын байгууллагын болон малчдын авсан зээл, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ.

Эдгээр бүртгэлүүд нь ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын хүрээнд шаардагддаг бүртгэлээс тусдаа, нэмэлт бүртгэл юм.

6.2 Малчдын байгууллага нь дараах бүртгэлийг үнэн зөв, бүрэн бүтэн, шинэчлэгдсэн байдлаар байгууллагын болон малчин өрхийн түвшинд цуглуулж, тогтмол хөтлөх боломжтой:

Тасралтгүй сайжруулах зорилтын хүрээнд дараах жагсаалтад байгаа үзүүлэлтүүд тус бүрийг нэг сайжруулах үзүүлэлт гэж үзнэ.

- a) Малчин өрхийн түвшинд мал тус бүрийн үдмын/үржлийн бүртгэл хөтлөх, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
- b) Малчин өрхийн түвшинд өмнөх жилд (малд) хэрэглэсэн эм, хийлгэсэн эмчилгээний бүртгэл, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
- c) Малчин өрхийн түвшинд малын эндэгдэл, хоргодлын бүртгэл, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
- d) Малчин өрхийн түвшинд малын өвчлөлийн бүртгэл, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;
- e) Малчин өрхийн түвшинд мал төллөх үед хүний оролцоо, тусламж хэрэгцээтэй байсан тухай бүртгэл, хамгийн багадаа жилд нэг удаа шинэчилнэ;

Малчны байгууллага нь бусад байгууллагууд (жишээлбэл төрийн байгууллагууд эсвэл орон нутгийн малын эмч)-ын бүртгэлээс хуулбарлан авах бүрэн боломжтой бол тусдаа давхар бүртгэл хийх шаардлагагүй.

Хүний оролцоо, тусламж гэдэгт кесар хагалгаа багтана.

6.3 Малчдын байгууллага нь бүртгэлүүдийг хамгийн багадаа 5 жил **хадгална**.

Эдгээр бүртгэлүүд нь ТННЭ-ийн Мөшгөлтийн тогтолцооны стандартын хүрээнд шаардагддаг бүртгэлээс тусдаа, нэмэлт бүртгэл юм.

Эдгээр бүх бүртгэлүүд нууц байх бөгөөд ашиг олох зорилгоор хэрэглэж болохгүй.

Энэ нь баталгаажуулалтад хамрагдсанаас хойших бүртгэлийг хэлж байгаа бөгөөд малчны байгууллага нь баталгаажуулалтад хамрагдахаас өмнөх 10 жилийн бүртгэлийг харуулах шаардлагагүй.

6.4 Малчдын байгууллага нь бүх малчин өрхүүдийн малын эндэгдэл, хоргодлыг үнэлэх бөгөөд эндэгдэл, хоргодлын түвшин онцгой өндөр байгаа малчин өрхийн малын хоргодлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой.

6.5 Малчдын байгууллага нь бүх малчин өрхүүдийн мал төллөх үед хүний оролцоо тусламж хэрэгтэй байсан эм малын нийт төллөсөн эм малд эзлэх хувийг үнэлж, онцгой өндөр байгаа малчин өрхөд мал төллөх үед хүний оролцоо, тусламж шаардлагатай төлөлтийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой.

 *Хүний оролцоо, тусламж гэдэгт кесар хагалгаа багтана.*

7. Тасралтгүй сайжруулалт

7.1 Малчдын байгууллага нь дахин үнэлгээнд орох үед өмнөх үнэлгээний үеэр хэрэгжүүлээгүй байсан гурван сайжруулах шалгуур үзүүлэлтийг хангахаас гадна өмнө хэрэгжүүлж байсан сайжруулах үзүүлэлтүүдийг үргэлжлүүлэн хангаснаар тасралтгүй сайжирч байгаагаа харуулна.

 *Зарим сайжруулах үзүүлэлтүүд нь зөвхөн тодорхой нөхцөл байдалд хамааралтай нөхцөлт шинж чанартай. Сайжруулах үзүүлэлт нь тухайн малчдын байгууллагад хамааралгүй тохиолдолд байнгын сайжруулалтыг харуулахад ашиглахгүй.*

 *Стандартын аль нэг шаардлага нь малчдын байгууллагын харьяа бүх малчдад хамааралгүй тохиолдолд тухайн малчдын байгууллага тасралтгүй сайжруулалтаа хангахын тулд тухайн шаардлагаас чөлөөлөгдөхөөр сонгох боломжтой.*

7.2 Малчдын байгууллага нь дараагийн дахин үнэлгээний үеэр 7.1-д заасан шаардлагыг хэрхэн биелүүлэхээр төлөвлөж байгаагаа харуулсан тасралтгүй сайжруулалтын төлөвлөгөөтэй **байна**.

7.3 16.11 болон 19.1-ээс бусад бүх сайжруулах үзүүлэлтийг хангасан малчдын байгууллага 7.1 болон 7.2-оос чөлөөлөгдөнө.

 *Малчдын байгууллага нь "ТННЭ-ийн шилдэг туршлага" хэрэгжүүлэгч гэж зарлахаасаа өмнө бүх сайжруулах үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай бөгөөд энэ нь эрчимжсэн фермийн аж ахуйг хэзээ ч "ТННЭ-ийн шилдэг туршлага" хэрэгжүүлэгч гэж үзэх боломжгүй юм.*

7.4 Малчдын байгууллага нь өөрийн малчин өрхүүдийн ашиглаж буй бэлчээрийн газрыг хамарсан нэг эсвэл хэд хэдэн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө (БМТ)-г дагаж мөрдөх бөгөөд үүнд дараах зүйлс **багтана**. Үүнд:

- a) Малчдын байгууллагын эрх зүйн статус;
- b) Малчдын байгууллагын бүх гишүүдийн жагсаалт;
- c) Тухайн газрын ерөнхий менежмент буюу зохион байгуулалтыг хэн хариуцах талаар товч тодорхойлолт;
- d) Тухайн бэлчээрийг бүх хэлбэрээр ашиглагч/хэрэглэгчдийн жагсаалт;
- e) Энэхүү стандартын "Биологийн олон янз байдал ба газар ашиглалт"-ын шаардлагыг хангахын тулд тухайн малчдын байгууллага болон малчин өрхүүд бусад бэлчээр ашиглагч/хэрэглэгчидтэй хэрхэн хамтран ажиллах тухай тодорхойлолт.

 *Малчдын байгууллага тухайн газрын менежментийг бүхэлд нь хариуцдаггүй бол тухайн газрыг ерөнхийд нь хариуцдаг байгууллага/мэргэжилтний боловсруулсан*

аливаа БМТ-г энэхүү стандартын "Биологийн олон янз байдал ба газар ашиглалт"-ын шаардлагуудтай яв цав нийцэхгүй байсан ч хэрэгжүүлэхээр сонгож болно. Энэ тохиолдолд малчдын байгууллага нь энэ стандартын шаардлагад нийцүүлэн тухайн БМТ-г өөрчлөхөд нөлөөлөх, хөгжүүлэх бүх боломжийг эрэлхийлэн саналаа өгч оролцох нь зүйтэй.

Малчдын байгууллага нь өөр өөр бэлчээр хариуцагчтай өөр өөр газар нутагт мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг малчин өрхтэй бол тухайн малчдын байгууллагын малчин өрхүүд нь өөрсдийнхөө мал аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй бүс нутагт хамаарах БМТ-г дагаж мөрдөх ёстой. Өөрөөр хэлбэл нэг малчдын байгууллагын малчин өрхүүд нь өөр өөр БМТ-г хэрэгжүүлж болно.

БМТ байхгүй тохиолдолд малчдын байгууллага нь өөрийн гэсэн БМТ-г боловсруулна.

- 7.4.1 Малчдын байгууллага нь бүх малчин өрхүүддээ БМТ-ний аливаа боловсруулалтад оролцох бодит боломжоор **хангана**.
- 7.4.2 Малчдын байгууллага нь БМТ-г боловсруулахдаа тухайн малчдын байгууллагад харьяалагддаггүй бэлчээр ашиглагчдын газар ашиглалтыг харгалзан **үзнэ**.
- 7.4.3 Малчдын байгууллага нь БМТ-д төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацааг тусгасан **байна**.
- 7.4.4 Малчдын байгууллага нь БМТ-д жил бүр хийгдэх мониторинг, үнэлгээ, хөгжүүлэлтийн төлөвлөгөөг тусгах боломжтой.
- 7.4.5 Малчдын байгууллага нь БМТ-д тухайн орон нутагт амьдардаг, малын гаралтай ширхэгт үйлдвэрлэлийн чиглэлээр ажилладаг, үйлдвэрлэлд оролцдог нутгийн иргэдийн уламжлалт мэдлэг, аргыг тусгаж, ашиглах боломжийг бүрдүүлэх боломжтой.
- 7.4.6 Малчдын байгууллага нь БМТ-г тухайн байгууллагын бүх малчин өрхүүдэд **таниулна**.
- 7.5 Малчдын байгууллага нь уур амьсгалын өөрчлөлтийн улмаас өөрчлөгдөж буй цаг агаарын төлөв байдлыг амжилттай даван түүлах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой.

Энэ нь малчин өрхүүдэд малын тоо толгойн зохицуулалт хийх, тодорхой шинж чанараар нь сонгон үржүүлэх замаар өөрчлөгдөн буй уур амьсгал, цаг уурын нөхцөл байдалд дасан зохицох боломжийг олгож байна гэсэн үг юм. Энэ нь малчдын байгууллага өөрсдийн нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулах тухай асуудал биш юм.

8. Газрын эрх, харилцаа

- 8.1 Малчид нь ашиглаж байгаа газраа хууль ёсны дагуу эзэмшиж эсвэл ашиглаж байгаагаа **нотолно**.
- 8.2 Малчдын байгууллага нь НҮБ-ын Уугуул (нутгийн) иргэдийн эрхийг хамгаалах тухай тунхаглал болон Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын 169-р конвенцод тодорхойлсны дагуу уугуул (нутгийн) иргэдийн зан заншил, соёлыг хүлээн зөвшөөрч, сахин **хамгаална**.

Үүнд соёл, экологи, эдийн засаг, шашин, оюун санааны онцгой ач холбогдолтой газруудыг тодорхойлох, хамгаалах зэрэг багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй.
- 8.3 Малчдын байгууллага нь өөрийн болон/эсвэл малчин өрхүүдийн үйл ажиллагааны улмаас “аливаа цөөнх эсвэл уугуул иргэд”-ийн эдийн засаг, хүний эрх, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, **хамгаална**.

- Энэхүү шаардлагын үүднээс нутгийн иргэдийг "аливаа цөөнх эсвэл уугуул иргэд"-ийн нэг төрөл гэж үздэг.
- 8.4 Малчдын байгууллага өөрөө эсвэл түүний төлөөллийн аль нь ч малчин өрхүүдээс өөрсдөд нь итгэмжилсэн эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд ашиглахыг **хориглоно**.
- Энэ нь [НҮБ-ын Даян дэлхийн гэрээний 10-р зарчмаар](#) тодорхойлогдсон авлига, хээл хахууль, шахалт дарамтаас урьдчилан сэргийлэх зорилготой юм.
 - Үүнд 'SFA Certified' ширхэгтийн худалдааны аливаа төрлийн нэмэгдэл үнэ болон хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн санхүүгийн үр өгөөжийг бүх малчин өрхүүдэд адил тэгш хүртээх зэрэг багтана.

Зарчим 2: Зохистой хөдөлмөр эрхлэлт

9. Хөдөлмөр эрхлэлт

- 9.1 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь ОУХБ-ын 29-р конвенцод тодорхойлсны дагуу албадан болон/эсвэл хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, үүнийг аливаа хэлбэрээр дэмжихийг **хориглоно**.
- *Үүнд ОУХБ-ын албадан хөдөлмөр эрхлэхтэй холбоотой үзүүлэлтүүд багтана.*
 - *Гэрээний нөхцөлөөс гаднах аливаа ажлыг нэмэлт болон/эсвэл илүү цаг гэж үзэх бөгөөд тохирох урамшууллыг ажилтанд олгоно*
- 9.1.1 Ажилтан ажиллуулдаггүй малчин өрхүүд энэ шаардлагаас чөлөөлөгдөнө.
- 9.2 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь ОУХБ-ын 111-р конвенцод заасны дагуу ялгаварлан гадуурхах үйлдэл гаргахыг **хориглоно**.
- 9.3 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь ОУХБ-ын 190-р конвенцод заасны дагуу хэн нэгэнд хүчирхийлэл, дарамт шахалт үзүүлэхийг **хориглоно**.
- 9.4 Малчдын байгууллага болон/эсвэл малчин өрхүүдэд ажиллаж байгаа бүх ажилчид нь хөдөлмөрийн гэрээтэй байх бөгөөд гэрээнд тохиролцон ажлын нөхцөл болон цалин урамшууллыг тодорхойлсон **байна**.
- *Энэхүү гэрээ нь бичгээр эсвэл аман байж болох ч хоёр тал гэрээний нөхцөлийг харилцан тохиролцсон байна.*
 - *Тохиролцсон ажлын нөхцөл гэдэг нь гэрээнд заасан ажлын тогтмол цаг, гүйцэтгэх ажил үүргийг хэлнэ.*
 - *Шаардлагатай тохиолдолд гэрээнд ямар үед гэрээт ажилтан нь малын эндэгдэл хоргодолд санхүүгийн хувьд хариуцлага хүлээх, хэрхэн нөхөн төлөх зэрэг тодорхой нөхцөлүүдийг оруулна.*
- 9.5 Малчдын байгууллага нь өөрийн байгууллага болон/эсвэл малчин өрхүүдэд ажиллаж байгаа бүх гэрээт ажилчид нь тухайн улсын хууль тогтоомжийн хүрээнд тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр эсвэл хамтын тохиролцоогоор тогтоосон цалингийн аль өндөр дүнгээр нь цалин хөлсийг **олгуулна**.
- 9.6 Малчдын байгууллага нь ажилтны хүйс, ажлын төрөл, шашин шүтлэг, улс төрийн байдал, үндэс үгсаа, нас болон бусад хүчин зүйлээс үл хамааран тухайн байгууллага болон/эсвэл малчин өрхүүдэд гэрээгээр ижил төрлийн ажил хийж буй ажилчдад ижил хэмжээтэй хөдөлмөрийн хөлсийг **олгуулна**.
- *Энэхүү цалин хөлс нь зөвхөн малчдын байгууллагад эсвэл малчин өрхүүдийн дунд ижил байхыг илтгэх бөгөөд малчдын байгууллага болон малчин өрхүүд бүгд хоорондоо ижил цалин хөлстэй байна гэсэн үг биш юм.*
- 9.7 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь ОУХБ-ын 182 дугаар конвенц болон 190 дугаар зөвлөмжид тодорхойлсны дагуу хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр ба/эсвэл хүүхдэд аюултай хөдөлмөрийг эрхлүүлэхийг **хориглоно**.
- 9.8 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь сургуулийн насны хүүхдүүдийг мал маллах ухаанд сургахдаа зөвхөн хичээлийн бус цагийг **ашиглана**.

10. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал

- 10.1 Малчин өрх нь ажлын орчин, ажиллах нөхцөл нь мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд оролцогчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй байдлыг тодорхойлж, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй аливаа эрсдэлийг тухайн малчин өрх өөрөө **бууруулна**.
- 10.2 Малчин өрх нь мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд оролцогчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг өртөж болзошгүй бүх хүнд мэдээлж, эрсдэлийг бууруулах үүрэг хариуцлагыг эрсдэлтэй хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцаж буй хүнд **өгнө**.
- 10.3 Машин механизм ашиглаж байгаа тохиолдолд малчин өрх нь тухайн машиныг аюулгүй ашиглах зааварчилгааг ажиллуулж буй хүнд хүртээмжтэй, ойр газар **байршуулна**.
- 10.4 Машин механизм ашиглаж байгаа тохиолдолд малчин өрх нь машин механизмын эвдрэл, эд ангийн доголдол гарах магадлалыг хамгийн бага байлгахын тулд засвар үйлчилгээг хийж, зөв **хадгална**.
- 10.5 Малчин өрх нь ажилчид, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд оролцогчдыг шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр ямар нэг үнэ төлбөргүй **хангана**.
- 10.6 Малчин өрх нь ажилчид, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд оролцогчдыг хүртээмжтэй үндны үс болон угаалга хийх аюулгүй байгууламжаар **хангана**.
- 10.7 Малчин өрх нь галын аюулаас хамгаалах хэрэгсэл, дохиоллоор хангаж, засвар үйлчилгээ **хийнэ**.
- 10.7.1 Малчин өрх нь ажилтан авч ажиллуулдаггүй эсвэл хүмүүс байршиж ажилладаггүй бол галын дохиоллын шаардлагаас чөлөөлөгдөнө.
- 10.8 Малчин өрх нь хүндэтгэх шалтгаан байхгүй л бол дараах зүйлсээр **хангана**:
- a) Ажилчдын тоо, хүйсийн онцлогт тохирсон цэвэрхэн, эрүүл ахуйн шаардлага хангасан угаалга, ариун цэврийн байгууламж;
 - b) Аврах замын зурааснууд нь тодорхойгүй бол тодорхой тэмдэглэгээтэй, цоожгүй, чөлөөтэй нээгдэх ослын гарц;
 - c) Жирэмсэн эмэгтэйчүүдэд тохиромжтой ажиллах нөхцөлөөр хангах, эсвэл ажлын байр нь тохиромжгүй бол өөр ажлын байрны зохион байгуулалт хийх.
- 10.9 Малчин өрх нь дараах зүйлсээр хангах **боломжтой**:
- a) Ажилчдад зориулсан хооллох болон хүнсээ хадгалах эрүүл ахуйн шаардлага хангасан байгууламж;
 - b) Хүүхэд асрах, хөхүүлэх байгууламж.
- 10.9.1 Мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаандаа ажилтан авч ажиллуулдаггүй малчин өрхүүд эдгээр сайжруулах үзүүлэлтүүдээс чөлөөлөгдөнө.
- 10.10 Малчдын байгууллага нь малчин өрхүүддээ байгаль орчноос ажилчид халдварт өвчин тусах эрсдэлийг бууруулах орон нутгийн хэмжээнд тохирсон арга дадлуудыг хэрэгжүүлж буй эсэхэд **анхаарна**.

Зарчим 3: Биологийн олон янз байдал ба газар ашиглалт

11. Бэлчээр, бэлчээрийн даац

11.1 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашиглаж буй бэлчээр, түүний дотор нөөц бэлчээрийг тодорхойлж, тэдгээр бэлчээр хоорондох улирлын нүүдэл, бэлчээр ашиглах хуваарийг тухайн бэлчээрийн ерөнхий менежментийг хариуцагчтай **зөвшилцөнө**.

■ Энэхүү зөвшилцөл нь Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд (7.4) тусгагдсан байна.

11.2 Малчдын байгууллага нь малын тоо нь бэлчээртээ тохирсон эсэхийг **баталгаажуулна**.

■ Энэ нь тохиромжтой малын тоог тогтоохдоо ургамал, амьтны унаган зүйлийн ач холбогдол, газрын төрөл, бэлчээрийн чанар, улирлын нөхцөл, малын төрөл, бэлчээрийн даац хэтрэх магадлал зэргийг харгалзан үзнэ гэсэн үг.

12. Байгаль хамгаалал ба нөхөн сэргээлт

12.1 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашиглаж буй газрынхаа байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хадгалан, хамгаалж буй эсэхэд **хяналт тавина**.

12.2 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашиглаж буй газрын байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг цаг хугацааны явцад сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх **боломжтой**.

12.3 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашиглаж буй газарт байгаа байгалийн усны голдирол, ус намгархаг газрыг тогтоож, малчин өрхүүдийн үйл ажиллагааны нөлөөгөөр усны нөөцийг доройтуулах, бохирдуулах болон хурдасчихаас сэргийлэх арга хэмжээг **хэрэгжүүлнэ**.

12.4 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашиглаж буй газарт байгаа байгалийн усны голдирол, ус намгархаг газрыг цаг хугацааны явцад нөхөн сэргээх арга хэмжээг авах **боломжтой**.

12.5 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь ашиглаж байгаа газартаа харь зүйлийн амьтан, ургамлыг санаатай болон санамсаргүйгээр нутагшуулахгүй байх арга хэмжээ **авна**.

12.6 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашигладаг газрын доройтсон хэсгийг **тогтооно**.

12.7 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашигладаг газрын доройтсон хэсгийг цаг хугацааны явцад сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх **боломжтой**.

12.8 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашигладаг газар нутаг дахь зэрлэг амьтдын нүүдэллэдэг коридор ба/эсвэл жимийг хаахгүй байгалийн хэвээр нь **хадгална**.

12.9 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийн нохой зэрлэг амьтад барих эрсдэлийг бууруулах орон нутагтаа тохирсон арга хэмжээг тухайн малчин өрхүүд авч хэрэгжүүлж буй эсэхэд **хяналт тавина**.

12.10 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашиглаж буй газарт мал, зэрлэг амьтад идэмжтэй бэлчээрийн ургамлын нөөцийг сайжруулах, тэр дундаа ургамлын

төрөл зүйл, бүрхэвчийг нэмэгдүүлэхэд орон нутгийн онцлогт тохирсон арга, туршлагыг хэрэгжүүлж байгаа эсэхийг баталгаажуулах боломжтой.

12.11 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ ашиглаж буй газарт хөрсний нягтрал, элэгдлийг багасгах, хөрсний органик бодисын алдагдлыг бууруулахын тулд орон нутгийн онцлогт тохирсон арга, туршлагыг хэрэгжүүлж буй эсэхийг баталгаажуулах боломжтой.

12.12 Малчдын байгууллага нь өөрөө болон түүний малчин өрхүүд мал аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй тухайн нутаг дэвсгэр дээр унаган, зэрлэг амьтан, ургамлын хамгаалалд чухал ач холбогдолтой газруудад малгүй бүс байгуулах боломжтой.

13. Байгаль орчныг бохирдлоос сэргийлэх

13.1 Малчин өрх нь мал, амьтны сэг зэмийг эрүүл ахуйн шаардлагын дагуу (орч. жишээ нь шатааж булах) **устгана**.

 Энэ нь өвчин тархахгүй байх аргаар устгал хийнэ гэсэн үг юм.

13.2 Малчин өрх нь газрыг цаашид бэлчээрийн зорилгоор ашиглах боломжгүй болгох аюултай бодисыг бэлчээрт хаяж, устгахыг **хориглоно**.

 Аюултай бодист малын сэг зэм, ашиглагдаагүй/хугацаа нь дууссан эм, тариа зэрэг химийн, эмнэлгийн болон биологийн хог хаягдал орно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй.

13.3 Малчдын байгууллага нь аюултай бодисын нөлөөнд өртсөн газрыг цаг хугацааны явцад нөхөн сэргээх арга хэмжээ авах боломжтой.

13.4 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь хортонтой тэмцэхэд биологийн, физикийн болон бусад химийн бус аргыг нэн тэргүүнд **ашиглана**.

13.5 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь хортны тархалтын түвшин нь зөвхөн мал амьтан эсвэл бэлчээрт хор хөнөөл учруулж болзошгүй нөхцөл байдалд хүрсэн үед л хортон устгалын бодис **хэрэглэнэ**.

13.6 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь хортон устгалын бодисыг зөвхөн түүнд тэсвэртэй болох буюу дасал болох эрсдэлийг бууруулах арга замаар **хэрэглэнэ**.

13.7 Малчдын байгууллага болон малчин өрхүүд нь олон улсын хоригт орсон хортон устгалын бодис хэрэглэхийг **хориглоно**.

 Хориотой хортон устгалын бодис гэдэг нь [PAN Олон улсын хориотой пестицидийн нэгдсэн жагсаалтад](#) багтсан бодисууд юм.

Зарчим 4: Малын тавлаг байдал

14. Малтай харьцах болон малын арчилгаа, маллагаа

- 14.1 Малчин өрхүүд нь малтай энэрэнгүй харьцаж, бие махбодын зодуур үзүүлэхгүй, айдаст автуулахгүй **байлгана**.
- *Энэ нь малыг өшиглөх, цохих, гишгэлэх, хашааны хаалгаар хавсарч цохих, шидэх эсвэл өндрөөс унагаах, мөн арьс, үс, сүүл, эвэр, чих, толгой, хүзүү, хойд хөлөөс нь чирэх эсвэл өргөхийг хориглоно гэсэн үг.*
 - *Энэ нь мөн малыг элдэн хөөх эсвэл шилбүүр, ташуур, мод, чулуу болон цахилгаан хэрэгсэл ашиглан цохиж болохгүй гэсэн үг.*
 - *Энэ нь малчин өрх нь нь малтай харилцан итгэлцлийг бий болгож, сүрэг дотор тайван, айдасгүй, аливаа үйлдэлд дуулгавартай байх боломжтой байдлаар харьцана гэсэн үг.*
 - *Энэ нь мал нь малчинд тайван, айдасгүй, дуулгавартай хариу үйлдэл гаргана гэсэн үг.*
- 14.2 Малчин өрх нь аливаа төл болон өсвөр мал, хээлтэй мал, гэмтсэн, доголон, өвчтэй малд онцгой анхаарал **хандуулна**.
- 14.3 Малчин өрх нь малыг зөвхөн үндэслэл бүхий тайлбартай, зайлшгүй тохиолдолд, шаардлагатай хугацаагаар уях эсвэл хашаанд түр хорих бөгөөд бусад тохиолдолд удаан хугацаагаар уяатай эсвэл хашаанд байлгахыг **хориглоно**.
- *Малыг уях, хашаанд хорих үндэслэл нь зөвхөн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагыг хангахын тулд байна.*
- 14.4 Малчин өрх нь малыг дасал болсон сүрэгт нь байлгаж, сүргийн бусад малтай ижилдэх, дасах боломжийг **бүрдүүлнэ**.
- 14.5 Малчин өрх нь хээлтүүлэгчийг үржлийн бус үед сүргээс тусгаарлахыг хориглоно.
- 14.6 Малчин өрх нь малыг зөвхөн үндэслэл бүхий тайлбартай, зайлшгүй тохиолдолд, шаардлагатай хугацаагаар тусгаарлалтад байлгах бөгөөд бусад тохиолдолд удаан хугацаагаар тусгаарлалтад байлгаж **болохгүй**.
- *Малыг тусгаарлалтад байлгах үндэслэл нь зөвхөн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагыг хангахын тулд байна. Энэхүү стандартын бусад шаардлагыг хангасан тохиолдолд тээвэрлэлт хийх нь мөн зөвшөөрөгдөх үндэслэл болно.*
- 14.7 Малчин өрх нь малыг өдрийн дунд үед тохиромжтой хугацаагаар амрах боломжийг **олгоно**.
- *Өдрийн дунд үе нь нар эгц өндөрт хүрж, хамгийн хурц байх үе юм.*
 - *Ямааны хувьд тохиромжтой хугацаа нь хамгийн багадаа хоёр цаг юм.*
- 14.8 Малчин өрх нь цахилгаан хатгуур, цахилгаан иммобилизатор (цахилгаан гүйдлээр хөдөлгөөнгүй болгогч төхөөрөмж) болон түүнтэй адилтгах цахилгаан төхөөрөмжийг ашиглахыг **хориглоно**.
- 14.9 Малчин өрх нь малыг халуун төмрөөр тамгалахыг **хориглоно**.
- 14.10 Малчин өрх нь мал, амьтны сэг зэмийг малын хот, мал бэлчээрлэх газар, сүргийн бусад малд харагдах газраас нэн даруй **зайлуулна**.

■ *Малчин өрх нь сэг зэмийг булж, шатааж устгах зориулалттай газрыг харуулах эсвэл зааж өгөх боломжтой байна.*

15. Ноолуур самнах

15.1 Малчин өрх нь ямааг зөвхөн түршлагатай хүнээр, зөв хадгалсан, зориулалтын самаар биед нь гэмтэл учруулахгүй зөөлөн **самнана**.

■ *Жишээлбэл, ноолуур самнах явцад арьсыг шархдуулж, гэмтээгээд байгаа тохиолдолд ирийг мохоох эсвэл зөөлөн самнана.*

15.2 Малчин өрх нь ямааг самнах зорилгоор малын хөдөлгөөнийг хорихдоо (жишээлбэл хөлийг нь уях) зөвхөн цусны эргэлтийг хязгаарлахгүй, өвтгөхгүй эсвэл биед нь гэмтэл учруулахгүй байх аргыг **хэрэглэнэ**.

■ *Ямааг самнах үед тухайн мал нь тайван, дөлгөөн байгаа тохиолдолд босоогоор эсвэл хэвтүүлж самнах хоёр аргыг хоёуланг нь зөвшөөрнө.*

15.2.1 Ямааг самнах зорилгоор түр хугацаагаар хөдөлгөөнийг нь хорьсон (жишээ нь хөлийг нь уясан) үедээ хараа хяналтгүй орхихыг **хориглоно**.

15.3 Малчин өрх нь зөвхөн малд сөргөөр нөлөөлөхгүй цаг агаартай үед л гадаа, задгай орчинд ямааг **самнана**.

■ *Энэ нь цаг агаарын таагүй нөхцөл байдал үүссэн үед дотор буюу битүү орчинд ноолуур самнах боломжгүй бол ноолуур самнах ажиллагааг түр зогсооно гэсэн үг.*

15.4 Малчин өрх нь ноолуур самнасны дараа, тухайн ямааг хэт дааруулахгүй байх арга хэмжээ **авна**.

■ *Жишээлбэл, ямааг хяргах арга (орч. БНХАУ-д ашигладаг арга) ашигласан тохиолдолд тэр даруй задгай бэлчээрт гаргаж болохгүй.*

■ *Дулаан байр, хашаагаар хангах боломжгүй тохиолдолд цаг агаарын гэнэтийн хүйтрэлээс сэргийлэхийн тулд ноолуурыг хяргахын оронд самнах аргаар бэлтгэнэ.*

15.5 Малчин өрх нь ноолуур самнахаас өмнөх дөрвөн цагийн хугацаанд тухайн малд өвс тэжээл, ус өгөхгүй (бэлчээрт гаргахгүй) бүрэн **хязгаарлана**.

15.6 Малчин өрх нь анх удаа самнуулж байгаа ямааг яарахгүй, болгоомжтой **самнана**.

■ *Энэ нь тухайн ноолуурыг бий болгож буй ямааг самнах үйл ажиллагаанд дасгах зорилготой.*

15.7 Малчин өрх нь ямааны ноолуурыг самнахдаа зөвхөн байгалийн жамаараа ноолуур хөөрсөн үед нь **самнана**.

16. Тэжээл болон усан хангамж

16.1 Малчин өрх нь малыг өдөр бүр цэвэр, аюулгүй ундны усаар бүрэн хангаж, ханатлаа уух нөхцөлийг **бүрдүүлнэ**.

■ *Энэ нь малын уух усыг өдөр бүр шалгана гэсэн үг.*

16.2 Малчин өрх нь малыг зөвхөн үндэслэл бүхий тайлбартай, зайлшгүй тохиолдолд, шаардлагатай хугацаагаар өвс тэжээл, усыг нь сойх бөгөөд бусад тохиолдолд удаан хугацаагаар өвс, усыг хязгаарлахыг **хориглоно**.

■ *Энэ нь зөвхөн шаардлагатай хугацаагаар л хязгаарлана гэсэн үг.*

- Өвс, усыг хязгаарлах үндэслэл нь зөвхөн тухайн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагыг хангахын тулд, жишээлбэл ноолуурыг самнах, ямааг саах, эмчилгээ хийхийн өмнө байна. Энэхүү стандартын бусад шаардлагыг хангасан тохиолдолд тээвэрлэлт хийх нь мөн зөвшөөрөгдөх үндэслэл болно. Тухайн малын ба/эсвэл малчдын аюулгүй байдлын төлөө бол хоногоор өвс, усыг хязгаарлах нь зөвшөөрөгдөх үндэслэл болно.*
- 16.3 Малчин өрх нь малыг хуучирч муудсан, хөгцөрч ялзарсан өвс, тэжээлээр тэжээхийг **хориглоно**.
- Үүнд өвчтэй малын сэг зэм ч багтана.*
- 16.4 Малчин өрх нь малыг бөөгнөрч шахцалдахгүйгээр тэжээл идэх, ус уух боломжтой байхаар тэжээлийн онгоц, уст цэгийн хүртээмжтэй, аюулгүй байдлыг **хангана**.
- 16.5 Малчин өрх нь малын эмчийн үндэслэл бүхий зөвлөгөө, зааварчилгаагүйгээр малыг малын дайвар бүтээгдэхүүн эсвэл загасны гурилаар хооллохыг **хориглоно**.
- Зөвшөөрөх үндэслэл нь зөвхөн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагыг хангахын тулд байна.*
- Өвчтэй малын дайвар бүтээгдэхүүнийг сүргийн бусад малд өгөх нь хэзээ ч зөвтгөх үндэслэл болохгүй.*
- 16.6 Малчин өрх нь малын өсөлтийг дэмжих зорилгоор өсөлтийн даавар идэвхжүүлэгч болон эмчилгээний бус антибиотик хэрэглэхийг **хориглоно**.
- 16.7 Малчин өрх нь малыг хөнөөлт, хортой ургамал идэхээс сэргийлэх арга хэмжээ **авна**.
- 16.8 Малчин өрх нь малыг ямар ч нөхцөлд тураахгүй, доройтуулахгүй байх тал дээр **анхаарна**.
- Туранхай гэдэг нь 5 онооны биеийн байдлын үнэлгээний хэмжүүрээр (1 нь хэт эцэнхий, 5 нь хэт илүүдэл жинтэй) мал нь 2-оос доош оноогоор үнэлэгдэх ёсгүй гэсэн үг юм.*
- 16.9 Малчин өрх нь малыг идэш, тэжээлийн шалтгаант өвчнөөр өвчлөхгүй байх нөхцөлийг **хангана**.
- Ноолуурын ямааны хувьд энтеротоксеми буюу дотрын хордлого (идэш тэжээлийн горим өөрчлөгдөж, хэт их цардуул, уураг, сахар бүхий тэжээлийн хэмжээ огцом нэмэгдэж, гэдсэн дэх Clostridium perfringens бактерийн хэмжээ огцом нэмэгдэж, малыг хордуулдаг), полиоэнцефаломалази (polioencephalomalacia), хээл тээх үеийн хордлого, шээсээр кальци алдах, булчин цайх өвчин орох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.*
- 16.10 Малыг зулгааж идэхэд тохиромжтой бутлаг, сөөглөг ургамал бүхий бэлчээрт бэлчээрлэх боломжийг малчин өрх **олгоно**.
- Эдгээр нь сөөг, бутны шинэхэн нахиа байж болно.*
- 16.11 Мал нь шим тэжээлийн ихэнх хэсгийг бэлчээрээс буюу хивэх боломжтой өвслөг ургамлаар дамжуулан авдаг гэдгийг малчин өрх баталгаажуулах **боломжтой**.
- 16.12 Мал нь шим тэжээлийн ихэнх хувийг нэмэлт тэжээлээс авдаг бол малчин өрх нь Тэжээлийн менежментийн төлөвлөгөөтэй байна.

16.13 Малын шим тэжээлийн ихэнх хувийг нэмэлт тэжээл эзэлдэг бол тухайн малын идэш тэжээл дэх өвслөг ургамлын эзлэх хувь нь малын хивэх хэрэгцээнд хангалттай байгаа эсэхэд малчин өрх **анхаарна**.

Малын шим тэжээлийн дийлэнх хувийг бэлчээрээс буюу хивэх боломжтой өвслөг ургамлаас авдаг бол хивэх хэрэгцээнд хангалттай гэж үзнэ.

16.14 Малын шим тэжээлийн ихэнх хувийг нэмэлт тэжээл эзэлдэг тохиолдолд малчин өрх нь малын идэш тэжээлд өөрчлөлт оруулахдаа хоол боловсруулах эрхтний хямралаас зайлсхийхийн тулд хамгийн багадаа хоёр долоо хоногийн хугацаанд аажмаар буюу дасгах байдлаар **өөрчилнө**.

17. Малын эмчилгээ ба ажиглалт

17.1 Малчдын байгууллага нь малын эмчийн тусламжтайгаар малчин өрхийн мал сүргийн тавлаг байдлыг хангаж буй байдал, малын эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээний арга барилд нь хяналт тавих зорилгоор жил бүр газар дээр нь үнэлгээ, хяналтыг хэрэгжүүлэх **боломжтой**.

17.2 Малчин өрх нь малыг өдөр бүр нэгээс доошгүй удаа ажиглаж, өвчин, гэмтэл, хэвийн бүс үйлдэл гаргаж буй эсэхийг **шалгана**.

17.2.1 Өвчтэй, доголон, гэмтсэн малд зохих эмчилгээ, арчилгааг хийж, тэжээлээр хангаж, хяналтад байлган, өдөрт дор хаяж 2 удаа ажиглалт **хийнэ**.

17.2.2 Халдварт өвчний шинж тэмдэг ажиглагдвал тухайн малыг сүргийн бусад малаас **тусгаарлана** (орч. харьяа мал эмнэлгийн газартаа 24 цагийн дотор мэдэгдэнэ).

Жич: малыг бүрэн тусгаарлахгүй байх шаардлага үүнд хамааралтай хэвээр байна.

17.3 Малчин өрх нь туруут малыг доголохоос урьдчилан сэргийлэх зорилгоор урт ургасан турууг нь **тайрна**.

17.3.1 Малчин өрх нь бүх малын турууг жилд хоёроос доошгүй удаа **шалгана**.

Жилд хоёроос олон удаа тайралт хийх шаардлага үүсэж болно (орч. ялангуяа суурин маллагаанд).

17.4 Малчин өрх нь шимэгч (паразит)-ийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг **хэрэгжүүлнэ**.

17.5 Шинээр худалдан авсан эсвэл шинээр сүрэгт нийлүүлэх гэж буй малыг сүргийн бусад бүх малаас хамгийн багадаа 21 хоногийн хугацаагаар хорио цээрийн дэглэмд, хагас тусгаарлалтад **байлгана**.

Хорио цээрийн дэглэм гэдэг нь малыг бие биедээ шууд хүрэлцэхээс сэргийлж тусад нь байлгахыг хэлнэ.

Хагас бус тусгаарлалт гэдэг нь хорио цээрийн дэглэмд байгаа малыг сүргийн бусад мал харагдахуйц, дуу чимээг сонсохуйц зайд тусгаарлалтад байлгахыг хэлнэ.

17.6 Малчин өрх нь сүргийн аль нэг малд хэрэглэсэн аливаа эмийн бодисыг (ургамлын гаралтай эм ч багтана) бүртгэж, эмчилгээний шалтгаан, эмчилгээ хийсэн огноог **бичнэ**.

17.6.1 Малчин өрх нь эмчилгээ хийлгэж буй малыг тус бүрд нь бүртгэх **боломжтой**.

17.7 Малчин өрх нь зөвхөн үндэслэл бүхий тайлбартай, хүндэтгэх шалтгаанаар мал (төл)-ыг **хөнгөлнө**.

Малыг (төлийг) хөнгөлөх үндэслэл нь зөвхөн тухайн малын болон мал сүргийн тавлаг байдлын төлөө, тухайлбал цус ойртолтоос урьдчилан сэргийлэх болон/эсвэл энэхүү стандартын бусад шаардлагыг хангахын тулд байна.

17.7.1 Малчин өрх нь малыг хөнгөлбөл зохих наснаас хэтэрсэн тохиолдолд үндэслэл бүхий тайлбар, хүндэтгэх шалтгаангүйгээр хөнгөлөхийг **хориглоно**.

Малыг (төлийг) хөнгөлөх үндэслэл нь зөвхөн малын тавлаг байдлын төлөө болон/эсвэл энэхүү стандартын бусад шаардлагыг хангахын тулд байна.

Хөнгөлбөл зохих нас нь ямааны хувьд ишиг 8 долоо хоногийн нас хүрсэн үе байна.

17.8 Малчин өрх нь малыг (төлийг) цэвэрхэн, зориулалтын багажаар, туршлагатай хүнээр хөнгөлүүлж, дараагаар нь малын эрүүл мэндийг тэтгэж, эдгэрэлтийг түргэсгэх эмчилгээ, арчилгаа **хийнэ**.

17.9 Малчин өрх нь мал хөнгөлөх үед өвдөлт намдаах эм, тариа хэрэглэх **боломжтой**.

17.10 Малчин өрх нь эр ямааны үнэр ялгаруулагч тосны булчирхайг авах, ишигний эврийн ургалтыг төөнөж зогсоох, ямааны эвэр тайрах болон молцгийг нь тайрч авахыг **хориглоно**.

18. Нядалгаа

18.1 Мал нь шим тэжээлийнхээ дийлэнх хувийг нэмэлт тэжээлээс авдаг тохиолдолд, нэгээс олон мал нэг дор нядалгаанд оруулах, мөн малын тоо толгойг багасгах эсвэл худалдааны мах үйлдвэрлэлийн зорилгоор малыг нядалж байгаа бол малчин өрх нь малыг төхөөрөхдөө хурдан хугацаанд муужруулах аргыг ашиглах ба нядалгааны явцад мал ухаан орж, сэрэхээргүй **байна**.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн зорилго нь малын өвдөлт, болон айдсыг багасгахад оршино.

18.1.1 Малчин өрх нь малыг төхөөрөхөөс өмнө хурдан хугацаанд муужруулж болох бөгөөд нядалгааны явцад мал ухаан орж, сэрэхээргүй **байна**.

18.2 Малчин өрх нь ямар арга ашиглаж малыг төхөөрч байгаагаас үл хамааран зөвхөн цэвэрхэн, зориулалтын багажаар, туршлагатай хүнээр **төхөөрүүлнэ**.

18.3 Малчин өрх нь ямар арга ашиглаж малыг төхөөрч байгаагаас үл хамааран найдвартай хурдан **төхөөрнө**.

18.4 Малчин өрх нь төхөөрөх гэж буй малыг төхөөрч эхлэх хүртэл нь төхөөрөх гэж буйг мэдэгдүүлэхгүй **байна**.

18.5 Малчин өрх нь төхөөрөх гэж буй малд ойрын хугацаанд, ойр орчимд нь мал төхөөрсөн гэдгийг мэдэгдүүлэхгүй **байна**.

Энэ нь тухайн мал өөрийг нь төхөөрөх хүртэл бусад малыг төхөөрч байхыг харах, сонсох эсвэл үнэрлэх боломжгүй байх ёстой гэсэн үг. Ингэснээр төхөөрөх гэж буй мал тайван байж, айдас түгшүүргүй байх юм.

18.6 Малчин өрх нь малыг нядалгааны зорилгоор амьдаар нь олон улсын худалдаанд борлуулахыг **хориглоно**.

19. Малын битүү байр, задгай хашаа

- 19.1 Малчин өрх нь малыг байгалийн бэлчээрт бэлчээхгүй (орч. ихэвчлэн байран маллагаа) байгаа тохиолдолд хүндэтгэх шалтгаанаа нотлон харуулах **боломжтой**.
- Малыг байгалийн бэлчээрт бэлчээхгүй байх үндэслэл нь зөвхөн малын тавлаг байдлын төлөө эсвэл энэхүү стандартын бусад шаардлагыг хангахын тулд байна. Энэхүү стандартын бусад шаардлагыг хангасан тохиолдолд тээвэрлэлт хийх нь мөн зөвшөөрөгдөх үндэслэл болно.
- 19.2 Мал нь ихэнх цагаа малын байр эсвэл хязгаарлагдмал хаалттай орчинд өнгөрүүлдэг (орч. ихэвчлэн байран маллагаа) бол тухайн малчин өрх нь малыг чөлөөтэй хөдөлгөөн хийх, идээшлэх, тоглоход тохиромжтой байгалийн орчныг **бүрдүүлнэ**.
- Бэлчээрийн мал аж ахуйн хувьд хангалттай хэмжээний байгалийн орчин бүрдсэн гэж үзнэ.
 - Ямааны хувьд энэ нь гуалин мод, хожуул, өргөгдсөн тавцан эсвэл шороон овоолго гэх мэтийг байршуулж авиран гарах нөхцөлийг хангана гэсэн үг.
 - Хаалттай орчин гэдэг нь малын чөлөөтэй хөдөлгөөнийг хязгаарлаж өгсөн орон зайг хэлнэ. Үүнд байр, хашаа хороо, тээврийн хэрэгсэл зэрэг багтах ба үүгээр хязгаарлагдахгүй.
- 19.3 Мал нь ихэнх цагаа малын байр болон хаалттай орчинд өнгөрүүлдэг (орч. ихэвчлэн байран маллагаа) бол малчин өрх нь малын тавлаг байдлыг хангах төлөвлөгөөг гаргаж, жил бүр нэгээс доошгүй удаа төлөвлөгөөг хянан **сайжруулна**.
- 19.4 Мал нь малын байранд ихэнх цагаа өнгөрүүлдэг (орч. ихэвчлэн байран маллагаа) бол малчин өрх нь хангалттай зай талбайтай байхаар тооцож, байрыг зохион **байгуулна**.
- Ямааны хувьд хангалттай зай талбай гэдэг нь битүү байранд нэг ямаанд хамгийн багадаа 2м² зай оногдохыг хэлнэ.
- 19.5 Мал нь хязгаарлагдмал орчинд ихэнх цагаа өнгөрүүлдэг (орч. ихэвчлэн байран маллагаа) бол малчин өрх нь малыг чөлөөтэй хөдөлгөөн хийх боломжтой задгай хашаагаар **хангана**.
- Энэ нь үндсэн битүү байрнаас гадна, нэмэлт задгай хашаа юм.
 - Энэ нь малын тавлаг байдлыг хангах үндэслэл бүхий шалтгаанаар тухайлбал шөнийн цагаар малын аюулгүй байдлын төлөө, тодорхой хугацаанд хязгаарлахаас бусдаар бол чөлөөтэй хөдөлгөөн хийх боломжоор байнга хангана гэсэн үг.
 - Ямааны хувьд хангалттай зай талбай гэдэг нь задгай хашаанд нэг ямаанд хамгийн багадаа 5м² зай оногдохыг хэлнэ.
- 19.6 Малчин өрх нь хэрэв малын байр, хашаа, тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэлд малыг ачих байгууламжийг ашигладаг бол эдгээр нь малыг гэмтээхгүй, зовоохгүй байх нөхцөлийг бодолцож барьсан байх бөгөөд засварлаж торддог **байна**.
- 19.7 Малчин өрх нь аливаа малын байр, хашааг аюултай хог хаягдал, объектоос ангид **байлгана**.
- 19.8 Малчин өрх нь малын байр, тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэлд мал ачих байгууламжийг ашигладаг бол эдгээрийг таагүй эсвэл хурц үнэргүй **байлгана**.

- Энд тавих зорилт бол мал бүрд аммиак буюу шүвтэр (шивтэр)-ийн түвшин нь 1-2 ррт хүргэхгүй байлгах буюу цаг тутамд 10-20 удаа агаар сэлгэж байх юм.
- 19.9 Малчин өрх нь байгалийн бус хиймэл гэрэлтүүлэг ашиглаж байгаа тохиолдолд, малыг нийт 24 цагийн 16-аас илүү цагаар байгалийн бус гэрэлд байлгахыг **хориглоно**.
- 19.10 Малчин өрх нь малыг өдрийн цагаар байгалийн гэрэлд байлгах нөхцөлийг **хангана**.
- 19.11 Малын байранд шал (орч. ихэвчлэн байран маллагаа) ашигласан бол шал нь малыг хэвтэхэд тохиромжтой **байна**.
- Энэ нь шал нь зөөлөн, гажаагүй, цэвэр, хуурай байх бөгөөд бетон эсвэл үүнтэй төстэй материалтай байж болохгүй гэсэн үг.
- 19.11.1 Малчин өрх нь өвчтэй, гэмтсэн, хээлтэй мал болон төлийг (1 нас хүрээгүй) завсартай шалан дээр байлгахыг **хориглоно**.
- 19.12 Малчин өрх нь бусад малаа завсартай шал дээр байлгах аас зайлсхийх боломжтой.
- 19.13 Малчин өрх нь малын байрнаас нойтон өтөг, бууцыг өдөр бүр **зайлуулна**.

20. Хамгаалах хашаа, нөмөр

20.1 Малчин өрх нь малыг цаг агаарын аливаа сөрөг нөлөөллөөс бүрэн хамгаалах нөмөртэй хашаа, хамгаалалтаар **хангана**.

 *Үүнд хэт халуун болон хүйтэн цаг агаар аль аль нь орно.*

 *Нөмөртэй хашаа, саравч, хамгаалалт нь байгалийн эсвэл хиймэл байж болно.*

20.2 Зэрлэг, махчин амьтдын эрсдэл байгаа тохиолдолд малчин өрх нь мал руу зэрлэг, махчин амьтад дайрч, гэмтээх эрсдэлийг бууруулах арга хэмжээ **авна**.

20.3 Малчин өрх нь төллөх дөхсөн, өвчтэй болон/эсвэл гэмтсэн малыг эх сүргээс нь болон бие биеэс нь тусгаарлах боломжтой хашаатай **байна**.

20.4 Малчин өрх нь төллөх дөхсөн эм малыг хашаа, саравчаар **хангана**.

21. Тээвэрлэлт

21.1 Малчин өрх нь өвчтэй, бэртэж гэмтсэн, нэмэлт тусламжгүйгээр өөрөө зогсох чадваргүй, хээл тээх сүүлийн хоёр сард байгаа мал, хүй нь эдгээгүй төл эсхүл тээвэрлэх явцад эрсдэлтэй малыг эмнэлгийн тусламж авахаар тээвэрлэхээс бусад тохиолдолд тээвэрлэхийг **хориглоно**.

21.2 Малчин өрх нь малыг хөлөөр нь түүхдаа ширүүлэхгүй, малыг цуцааж, ядраахгүй, хурдыг нь **тохируулна**.

21.3 Малчин өрх нь малыг тээвэрлэх үед халуун болон/эсхүл хүйтний хямралд өртөхгүй байх нөхцөлийг **бүрдүүлнэ**.

 *Биеийн илүүдэл дулаанаа гадагшлуулж чадахгүй үед халууны стресс буюу хямрал үүсдэг. Энэ тохиолдолд биеийн үндсэн температур өсөж, зүрхний цохилт нэмэгддэг.*

 *Хүйтний стресс буюу хямрал нь мал биеийн хэвийн температураа хадгалах боломжгүй болж, биеийн температур буурсан үе юм.*

 *Малыг эдгээр хямралаас хамгаална гэдэг нь хэт халууцуулах эсвэл хэт дааруулахгүй байна гэсэн үг.*

21.4 Малчин өрх нь малыг тээвэрлэхдээ хэвтэхэд хангалттай зайтай, тээврийн хэрэгслийн ачааны дээвэр нь тээвэрлэж буй мал босож зогсоход толгойд нь хүрэхээргүй хангалттай өндөрт **байлгана**.

21.5 Малчин өрх нь малыг тээвэрлэхээр ачихаас хоёр цагийн өмнө малын насанд нь тохирсон шим тэжээлтэй өвс тэжээл болон усаар **хангана**.

21.6 Малчин өрх нь малыг 8 цагаас дээш хугацаатай тээвэрлэх тохиолдолд 8 цаг тутамд малыг ус, тэжээлээр болон амрах боломжоор хангаж, аяллыг үргэлжлүүлэхээс өмнө хамгийн багадаа 8 цагийн түрш тээвэрлэж яваа хэрэгслээс буулгаж, хангалттай зай талбайд тааваар нь **байлгана**.

 *Энэ хугацаанд мал ханатлаа идэж, ундаалсан байх ёстой.*

 *Ямааны хувьд ямаа бүрд оногдох зай талбай 5м² байвал хангалттай гэж үзнэ.*

22. Химийн хорт бодисууд

22.1 Малчин өрх нь малыг химийн хорт бодист хүрэлцэхгүй, хордохгүй байх нөхцөлийг **бүрдүүлнэ**.

23. Үржил

23.1 Малчин өрх нь малыг үржүүлэхээр сонгохдоо малын эрүүл мэнд, тавлаг байдал болон тухайн бүс нутагт үржүүлэхээр зөвшөөрөгдсөн, байгаль цаг уур, орчинд тохирсон байдлыг харгалзан **үзнэ**.

Малчин өрх нь мал сүргийн үржлийн стратеги буюу төлөвлөлтөө тайлбарлах чадвартай байх ёстой бөгөөд малын хөл, туруу, шүд зэрэг нь генетикийн согоггүй байх ёстой. Мөн малын биеийн онцлог нь бүс нутаг, хүрээлэн буй орчиндоо тохирсон байна.

23.2 Малчин өрх нь малыг хэт бага настайд нь хээлтүүлэгт оруулахыг **хориглоно**.

Ямааны хувьд эмийг нь 12 сараас доош, эрийг нь 18 сараас доош настайд нь үржүүлж болохгүй.

23.3 Малчин өрх нь эм малыг үржилд хэт ойрхон давтамжтай оруулахыг **хориглоно**.

Ямааны хувьд 10 сар тутамд үржилд оруулах нь хэт ойрхон давтамжтай гэж үзнэ.

23.4 Малчин өрх нь малыг үржүүлэхдээ хээлтэгч болон хээлтүүлэгч малын харьцааг зохистой барьж, хээлтүүлэгч малыг хэт туйлдахаас **сэргийлнэ**.

Энэ нь нэг хээлтүүлэгч малд ногдох хээлтэгчийн тооны харьцааг хэлэх бөгөөд үүнийг хээлтүүлэгчийн насанд нь тохируулахыг.

23.5 Малчин өрх нь ямааны хээлтүүлэг хийхэд дараах зүйлсийг ашиглахыг **хориглоно**:

- a) мэс засал;
- b) өндгөн эсийг авах;
- c) үр хөврөл шилжүүлэх;
- d) цахилгаан төхөөрөмж ашиглан эр малын үрийн шингэнийг гарган авах.

23.6 Малчдын байгууллага нь клоны буюу хувилах аргаар гаргасан, генийн инженерчлэл ашигласан ба/эсвэл генийн засвар хийгдсэн малыг аль нэг малчин өрхийн эзэмшилд байхгүй гэдгийг **баталгаажуулна**.

24. Төл хүлээн авах, бойжуулах

24.1 Малчин өрх нь үндэслэл бүхий шалтгаангүй бол кесар хагалгаа хийхгүй **байна**.

24.2 Малчин өрх нь зөвхөн цэвэрхэн, зориулалтын багаж, хэрэгсэл ашиглан кесар хагалгааг хийх бөгөөд мэс заслын дараа эх малын эрүүл мэндийг тэтгэсэн, эдгэрэлтийг дэмжсэн арчилгааг **хийнэ**.

24.3 Малчин өрх нь урьдаас төлөвлөсөн кесар хагалгааг зөвхөн туршлагатай малын эмчээр **хийлгэнэ**.

■ Яаралтай үед кесар хагалгааг зөвхөн туршлагатай хүнээр хийлгэх бөгөөд үгүй бол эх мал болон/эсвэл төл малын аминд эрсдэл учруулж болзошгүй.

24.4 Малчин өрх нь шинээр гарсан төлийг хангалттай дулаан, цэвэр, хуурай байраар **хангана**.

24.5 Малчин өрх нь шинээр гарсан төлийг эхтэйгээ болон сүрэгт дасах боломжийг **олгоно**.

24.6 Малчин өрх нь яаралтай үед хэрэглэх уургийн хангалттай нөөцтэй **байна**.

■ Энэ нь төллөлтийн үе эхлэхээс өмнө хангалттай нөөц бэлдсэн байна гэсэн үг.

■ "Хангалттай" гэдэг нь төллөх малын тооноос хамаарна.

24.7 Малчин өрх нь дөнгөж гарсан төлийг төрснөөс хойш 24 цагийн дотор өөрөөр нь эсвэл хүний тусламжтайгаар хангалттай уургаар хооллох бөгөөд, анхны хооллолт нь төрснөөс хойш 2 цагийн дотор **байна**.

24.8 Малчин өрх нь зөвхөн цэвэр, зөв хадгалсан угж **ашиглана**.

24.9 Малчин өрх нь төлийг хангалттай том болтол нь сүүнээс гаргахгүй **байна**.

■ Ямааны хувьд ишиглээд 4 сар орчим (16 долоо хоног) болсон эсвэл наанадаж нас биед гүйцсэн ямааны жингийн 40 хувьтай тэнцэх жинтэй болсон тохиолдолд хангалттай том гэж тооцно.

24.10 Малчин өрх нь эхийн сүүндээ цадахгүй байгаа төлийг хангалттай том болтол нь угжих юм уу өөр эхэд авхуулж сүүгээр **хооллоно**.

• *Ямааны хувьд ишиглээд 4 сар орчим (16 долоо хоног) болсон эсвэл наанадаж нас биед гүйцсэн ямааны жингийн 40 хувьтай тэнцэх жинтэй болсон тохиолдолд хангалттай том гэж тооцно.*

24.11 Мал төллөх үед тухайн малчин өрхөд мал төллүүлэх туршлагатай болон мал төллөх үед тохиолддог нийтлэг асуудлуудыг сайн мэддэг, төллөх үед хүний туслалцаа хэрэгтэй байгаа эсэхийг тодорхойлох, хэзээ малын эмчийн туслалцаа авах талаар мэддэг дор хаяж нэг хүн **байна**.

25. Ажил уналга, эдэлгээний мал, амьтад

-  *Ажил, уналга, эдэлгээний мал, амьтан гэдэгт голчлон нохойг хамаатуулж байгаа боловч малын гаралтай ширхэгт (ноолуур)-ийг бий болгоход, үйлдвэрлэхэд ашиглагддаг бусад аливаа амьтдыг багтааж болно.*
- 25.1 Малчин өрх нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтдыг өдөр бүр зохимжтой хэмжээний хоол тэжээл, усаар **хангана**.
- 25.2 Малчин өрх нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтдад шаардлагатай үед эмчилгээ, арчилгааг түргэн шүүрхай **хийнэ**.
- 25.3 Малчин өрх нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтдад гэмтэл, айдас, дарамт учруулахгүйгээр **харьцана**.
- 25.4 Ажил, уналга, эдэлгээний мал, амьтдыг байнга уяатай байлгах эсвэл амьсгалыг нь боогдуулахаар уяхаас **сэргийлнэ**.
 -  *Үүнд татагдах тусам чивчирч чангардаг гинж болон уяа орох бөгөөд, үүнийг огт ашиглаж болохгүй.*
- 25.5 Малчин өрх нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтдыг зэрэмдэглэхийг **хориглоно**.
 -  *Үүнд нохойны шүд, сарвуу ба/эсвэл сүүлийг авах зэрэг багтана.*
- 25.6 Малчин өрх нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтдыг зохих вакцинд хамруулж, шимэгчийг **хянана**.
- 25.7 Малчин өрх нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтдыг бетон болон төмөр биш, дулаан, хуурай унтах талбайгаар **хангана**.
 -  *Малчин өрх нь цаг агаарын тааламжгүй нөхцөлд ажил, уналга, эдэлгээний мал, амьтдыг хэрхэн анхаардгаа тайлбарлах шаардлагатай.*
- 25.8 Малчин өрх нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтдыг арчлахад хангалттай хүрэлцээтэй, тохиромжтой анхны тусламжийн багцтай **байна**.
- 25.9 Малчин өрх нь ажил, уналга, эдэлгээний мал, амьтад нь бусад мал, амьтдыг гэмтээхгүй, айлгахгүй эсвэл өвтгөхгүй байх нөхцөлийг **бүрдүүлнэ**.

Зарчим 5: Ширхэгтийн чанарын сайжруулалт

26. Үржил

26.1 Малчин өрх нь малыг үржүүлэхээр сонгохдоо ширхэгт (ноолуур)-ийн урт, нарийн чанар (микрон), (орч. тухайн бүс нутагт үржүүлэхээр зөвшөөрөгдсөн байдал) болон өнгийг харгалзан **үзнэ**.

26.2 Малчдын байгууллага нь малчин өрхүүдийнхээ самнаж авсан ноолуурын урт, нарийн чанар (микрон) болон өнгийг сайжруулах зорилгоор үржил сайжруулах төлөвлөгөө боловсруулах **боломжтой**.

26.3 Малчдын байгууллага нь малчин өрхүүдээс бэлтгэсэн ноолуурын урт, нарийн чанар (микрон) болон өнгөнд жил бүр хяналт, шинжилгээ хийх **боломжтой**.

 Энэ нь олж авсан сургамжаа нэгтгэх, малчдын байгууллагын үржил сайжруулах төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах боломж юм.

26.3.1 Ширхэгт (ноолуур)-ийн чанарт ямарваа нэг асуудал, доголдол илэрсэн тохиолдолд малчдын байгууллага нь тухайн асуудлын учир шалтгааныг тодорхойлох, түүнд чиглэсэн арга хэмжээ авах **боломжтой**.

 Тасралтгүй сайжруулалтын зорилгоор ширхэгтийн чанарын асуудлыг хянаж, шийдвэрлэх нь нэг сайжруулах үзүүлэлт гэж тооцно.



Бэлтгэсэн:

Тогтвортой ноос ноолуурын эвсэл

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://sustainablefibre.org> сайтаас авна уу эсвэл
info@sustainablefibre.org хаягаар холбогдоно уу.